

Улаанбаатар хотын оёдлын үйлдвэрүүдэд хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн нөхцөл байдлын судалгаа

*МУИС-ийн ЭЗС-ийн ХАССТ,
судлаач, магистрант, Б.Наранчимэг*

Èéí á yíyöö ñoääääàáíú áæeëé 1ü áæääí ñäéööñüí íyäýööýí öýñýä áíéíö 1, äëüí çéëääýðò áæeëé ýðööýæ áóé ööööööööéí áð°íðëé øéíæ áåéääë, áæeëé ýðööýëöééí øäéööääí, ö°ä°ëí °ðëéí 1°ööëëéä ñoääëæ, öýíä ööööööéí ýðööééí àñooääë ö°íä°ööæ áåéääàá yñööééä òíäðööéäö çíðëéäí òíé þí.

Үндэслэл

“Хүүхдүүд эцэг эхийнхээ өмч хөрөнгө биш, өглөг буянаас хамаараптай эмзэг дорой хүмүүс ч биш. Тэд бол өөрийн гэсэн эрхтэй та бидний нэгэн адил хүн юм.”
Жюдит Эннүү

Хүүхэд насыг нь хулгайлж, эрүүл мэнд, заримдаа бүр амь насыг нь ч хохироож буй тэвчишгүй хүнд нөхцөлд өнөөдөр хэдэн арван сая хүүхэд ажиллаж байна. Судалгаанаас үзэхэд дэлхий дээр 5-14 насны нийт 250 сая орчим хүүхэд амьдралаа залгуулахын тулд хөдөлмөр эрхэлж байгаагийн 20-

24 хувь нь 5-11 насныхан байгаа бөгөөд тэд өөрсдийн нас, эмзэгхэн биедээ үл тохиорох хортой, хүнд нөхцөлд хөдөлмөрлөж байна (ОУХБ, НХХЯ, “182-р конвенци”).

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэхийн хэрээр сүүлийн жилүүдэд дэлхий нийтээрээ энэ асуудалд анхаарлаа хандуулах боллоо. 1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай” Конвенцийг Женев хотноо баталж хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй тэмцэх, тэдгээрийг устгах талаар дэлхий нийтээрээ зөвшилцэлд хүрсэн билээ (Монгол улс энэхүү Конвенцэд нэгдэн орсноор 2000 оны 10-р сард хуралдсан Монгол Улсын Их Хурлаараа баталсан). Уг конвенцэд хүүхдийн хөдөлмөр нь ядуурлаас эх үндэстэй бөгөөд түүнийг шийдвэрлэх арга зам нь ядуурлыг бууруулах, бүх нийтэд бага боловсрол олгох явдал гэж заажээ.

Хэдийгээр дэлхий нийтээрээ хүүхдийн хөдөлмөрийн асуудалд анхаарлаа хандуулан ажиллаж байгаа ч хүүхдийн хөдөлмөр ялангуяа хөгжиж буй орнуудад өргөн цар хүрээтэйгээр, зарим тохиолдолд бүр хүнд дорой нөхцөлд оршсоор байгаа нь хүүхдийн хөдөлмөрийн асуудал нь угтаа нарийн төвөгтэй байгаагаас шалтгаалж буй хэрэг юм (ОУХБ, ОУПХ, 2002).

Манай улсын хувьд хүүхдийн хөдөлмөр эрхлэлт нь цоо шинэ үзэгдэл биш бөгөөд өмнөх тогтолцооны үед ч байсан байна. Гэхдээ албан баримтаас үзэхэд хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн тоо тогтвортой буурч байжээ. Тухайлбал, 16 хүртэлх насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлт 1960 онд 13.0, 1970 онд 8.4, 1980 онд 4.3, 1990 онд 2.5 мянга болж ихээхэн буурсан байна (Н. Содномдорж, 1998).

Монголчуудын дунд хүүхэд ажил хөдөлмөр хийх нь буруудахгүй бөгөөд хүүхэд гэр ахуйнхаа ажилд туслах, өрхийн аж ахуйгаа эрхлэхэд эцэг эхдээ тус дэм болохыг тэднийг амьдралд бэлтгэх сургуулийн нэгээхэн хэсэг гэж үздэг хүүхдийг хөдөлмөрөөр хүмүүжүүлэх хандлага олон нийтэд түгээмэл байдагтай холбоотой. (Т.Амгалан, 2003). Гэтэл сүүлийн арав гаруй жилийн хугацаанд хүүхдийн ажлын хэлбэр, нөхцөл өөрчлөгдөж, хүүхдийг амьдралд бэлтгэх сургууль болохоосоо илүү хүүхдийн ирээдүйн хөгжлийн баталгаа болсон нийгэмших үйл явцыг боогдуулж, боловсролд хамрагдах боломжийг хааж, бие бялдрын болон оюун санааны хөгжлийг сааруулж цаашлаад нийгэм эдийн засгийн хөгжил дэх сөрөг үр дагаварыг гүнзгийрүүлж, хүүхдийн хүмүүжил, зан суртахуунд сөрөг үр дагавар учруулахуйц шинж чанартай болж байна (АХИС, 2001, Т.Амгалан, 2003, Г.Батчимэг, 2000).

Үндэсний Статистикийн Газар, Азийн Хөгжлийн Банктай хамтран 2002-2003 онд үндэсний хэмжээнд явуулсан судалгаагаар 5-17 насны нийт 68580 хүүхэд ажил эрхэлж байгаагийн дийлэнхи нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байна. Гэхдээ тэдгээр хүүхдүүдийн 10 хүүхэд тутмын 9 нь өрхийн бизнест цалин хөлсгүй ажиллаж байна гэсэн үр дүн гарчээ.

Манай улсын нийгэм эдийн засаг шинэ харилцаанд шилжиж өхөлсэн 1990-ээд оноос хойш шилжилтийн сөрөг үр дагавар болох ажилгүйдэл, ядуурал, шилжих хөдөлгөөн, сургууль завсардалт эрс нэмэгдсэн нь хүүхдүүд хөдөлмөр эрхлэх үндсэн шалтгаан, нөхцөл болж байна.

Хот, хөдөө дэх сургууль завсардсан хүүхдүүдийн дунд хийсэн судалгаагаар, сургууль завсардсан хүүхдүүдийн 21,1 хувь нь ажил эрхлэх шалтгаанаар сургуулиас завсардсан байна (НҮБ-ын Хүүхдийн сан, 2000).

Ажил эрхэлж буй хүүхдүүд сурах боломж нөхцлөөр хязгаардлагдмал болж байгаагийн зэрэгцээ цаг агаарын хүнд нөхцөлд, ариун цэврийн наад захын шаардлага хангагүй орчинд олон цагаар ажиллах, ажил хийх үедээ бэртэж гэмтэх, өвчинд нэрвэгдэх зэргээр эрүүл мэндээрээ хохирч байна.

Эрүүл мэндийн эрдэм шинжилгээний төвөөс явуулсан судалгаанаас үзэхэд хөлсний ажил хийж буй хүүхдүүдийн эрүүл мэндийн байдал сайнгүй байгаа юм. Тэдний 72.4 хувь нь ямар нэг суурь өвчтэй байгаагийн 13.6 хувь нь гэдэс дотрын өвчин, 22.7 хувь нь бөөр нуруу, үе мөчний өвчтэй ажээ. Түүнчлэн судалгааны үр дүнгээс харахад хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 40.9 хувь нь тамхи татах зуршилтай гэжээ. Энэ бүх үр дагаваруудад хөдөлмөрийн нөхцөл байдал, цаг агаарын хүнд нөхцөл, хүнс тэжээлийн дутагдал зэрэг олон шалтгаанууд нөлөөлдөг байна.

Гэвч ядуурал, ажилгүйдэлтэй холбоотойгоор бага насын болон насандаа хүрээгүй хүмүүс эрүүл энх өсч хөгжихэд сөрөг нөлөөтэй хүнд, тэвчишгүй хэлбэрийн ажил хөдөлмөр эрхлэх явдал баагүй байсаар л байна.

Хүүхдүүдийн хөдөлмөр нь хямдхан олдохоос гадна тэд дуугүй, хүлцэнгүй ажиллах хүч болж байдгаараа хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээ нь нэмэгдэж байгаа юм. Судлаачдын хийсэн судалгаанаас үзвэл монгол улсын хэмжээнд хүүхдүүд аяга таваг угаах, гутал тослох, жижиглэнгийн бараа зарахаас авахуулаад алт, жонш, нүүрсний уурхайнуудад ажиллах хүртэл ойролцоогоор 73 төрлийн ажил хөдөлмөр эрхэлж байна гэсэн тооцоо байна.

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн бодит нөхцөл байдал, түүнтэй холбоотой олон талт асуудлуудыг үнэн зөв тодорхойлж чадахуйц мэдээлэл, судалгаа чухал юм. Одоогоор хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл байдлыг нэлээд хэдэн талаас нь тухайлбал, биеэ үнэлж байгаа охидууд, мал маллаж байгаа хүүхдүүд, зах дээр, алтны болон жонш, нүүрсний уурхайнуудад, хогийн цэг дээр ажил эрхэлж байгаа хүүхдүүдийн ажлын нөхцөл байдлуудын талаар судалгаа, шинжилгээний ажлууд хийгдсэн боловч ихэнх нь албан бус салбарыг хамаарч байгаа юм. Хүүхдийн хөдөлмөр албан бус салбарт төвлөрч байгаа ч албан сектор буюу үйлдвэр, аж ахуйн нэгж газруудад хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн ажлын нөхцөл байдал ямар байгаа болон тэнд хүүхдийн эрх зөрчигдэж байгаа эсэх талаарх тоо мэдээлэл хомс байгаа юм.

Энэхүү судалгааны ажлаар оёдлын үйлдвэрт ажил эрхэлж буй хүүхдүүдийн ерөнхий шинж байдал, ажил эрхлэлтийн шалтгаан, хөдөлмөрийн нөхцлийг

судалж, тэнд хүүхдийн эрхийн асуудал хөндөгдөж байгаа эсэхийг тодруулах боломжтой болно. Тиймээс тус судалгааны үр дүнг албан секторт (оёдлын үйлдвэрүүдэд) хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтээс үүдэн гарч буй тулгамсан асуудлуудыг шийдвэрлэх, зөрчигдөж буй эрх ашгийг хамгаалах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож, хөдөлмөрийн нөхцөл байдлыг нь сайжруулах, шаардлагатай тохиолдолд хөдөлмөрөөс нь хөндийрүүлэх зэрэг бодлогын чанартай арга хэмжээ авах, бодитой мэдээлэлд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах, сургалт, сурталчилгаа болон судалгаа шинжилгээний ажилд суурь мэдээлэл болгон ашиглах боломжтой.

Судалгааны ажлын зорилго

Улаанбаатар хотын оёдлын үйлдвэрүүдэд хөдөлмөр эрхэлж байгаа 18 хүртэлх насын хүүхдүүдийн хөдөлмөрийн шалтгаан, нөхцөл байдлыг судлах явдал энэхүү судалгааны үндсэн зорилго юм. Энэхүү зорилгын хүрээнд дараахь зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- ◆ Оёдлын үйлдвэрт хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн шалтгааныг судлах;
- ◆ Үйлдвэрт хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн төрлүүдийг тогтоох;
- ◆ Хүүхэд, ажил олгогч нарын хооронд албан ёсны гэрээ хийгддэг эсэхийг судлах;
- ◆ Оёдлын үйлдвэрт хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн нөхцөл байдлыг судалж, тэдний эрх зөрчигдөж байгаа эсэхийг тодруулах

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зарим ойлголт, тодорхойлолтууд

Хүүхэд: 1989 онд тунхагласан НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, 1999 онд баталсан ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хөдөлмөрийн конвенц (182)-д “18-аас доош настай хүн амыг хүүхэд гэнэ” гэж тодорхойлсны дагуу энэхүү судалгааны ажилд 18 хүртэлх насын хүн амыг хүүхэд гэсэн тодорхойлолтоор авч үзлээ.

Хүүхдийн хөдөлмөр: Хүүхдийн хөдөлмөр гэдэг нь байнгын эсвэл улирлын чанартай байнга хийдэг, нас бие, сэтгэхүйн онцлогт нь тохироогүй, эрүүл байх сурч боловсрох, хөгжих, амрах эрхийг нь хөсөрдүүлж байдаг ажил буюу мөлжлөгийн шинжтэй хууль бус үйл ажиллагаа юм.

Ажил олгогч: Бусдад хөлс төлөн ажил хийлгэж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын удирдлагыг ажил олгогч гэнэ.

Оёдлөл: Бүтээгдэхүүний тухайн нэг хэсгийг (ханцуй, зах, эх бие г.м) оёх үйл ажиллагаа.

Индүүдлэг: Завсрын болон эцсийн бүтээгдэхүүнийг индүүдэх ажиллагаа.

Уттлагч/савлагч: Эцсийн бүтээгдэхүүнийг савлах ажиллагаа.

Зөөгч: Оёдлын үйлдвэрийн материал болон бүтээгдэхүүнийг ачиж, буулгах, зөөх үйл ажиллагаа.

Дагалдан буюу туслах: Оёдлын аль нэг дамжлага дээр болон дамжлагын бусад ажлуудад туслах, дагалдаж суралцах.

Цэвэрлэгээний ажил: Оёдлын үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүнүүд болох хувцаснуудын илүүдэл утас, хогийг түүх ажиллагаа.

Судалгааны аргачлал, арга зүй

Судалгаанд хамрагдах оёдлын үйлдвэрүүдийг сонгохдоо санамсаргүй, зорилтот түүврийн аргыг ашигласан. Харин оёдлын үйлдвэрт ажиллаж буй хүүхдүүдийн шинж байдал, ажил эрхлэлтийн төрөл, хөдөлмөрийн нөхцөл байдал, нэг өдрийн ажлын цагийн үргэлжлэх хугацаа, хөдөлмөрийн гэрээтэй ажилладаг эсэхийг анкет асуулгын аргаар, үйлдвэрүүдийн хөдөлмөрийн нөхцөл байдал, эрүүл ахуйн орчин, ажлын байрны тохиромжтой байдал, ажлын үнэлгээ, хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдэд тулгарч буй бэрхшээлүүд, дарамт, шахалтын талаарх мэдээллийг ганцаарчилсан ярилцлагын аргаар тус бүр цуглуулсан.

Судалгааны мэдээллийг 2004 оны 1-ээс 4-р саруудад цуглуулж, боловсруулалт хийв. Судалгааны үр дүнг боловсруулж, тайлан бичихдээ статистикийн тайлбарлах арга зүйг ашигласан.

Судалгааны хамрагдалт

Судалгаанд Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулж буй оёдлын 9 үйлдвэрүүдэд хөдөлмөр эрхэлж буй, 18 хүртэлх насны нийт 123 хүүхдийг хамруулсан бөгөөд тэдгээрээс 10 хүүхэд сонгож ганцаарчилсан ярилцлагад хамруулав.

Хүснэгт 2.1. Оёдлын үйлдвэрүүдэд хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн тархалт

Үйлдвэр	Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд	
	хувь	тоо
АООСС	13.0	16
Диорва	13.8	17
Эй Ти Эм	10.6	13
Тэмүүжин менж	10.6	13
Айтекс	10.6	13
Болд трейдинг	10.6	13
Сотома	12.2	15
Тинфар интернейшнл групп	9.8	12
Хун хуа жин	8.9	11
Бүгд	100.0	123

Судалгааны хязгаарлагдмал байдал, бэрхшээл

Судлаач бие даасан судалгаа хийж байгаа учраас санхүүгийн болон хүн хүчний талаар нэлээд бэрхшээлтэй тулгарч байлаа. Дүүргүүдийн статистикийн хэлтсүүд дээр үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн бүртгэл байдаг ч хангалттай, ашиглахад бэлэн мэдээллийг агуулж чаддаггүй, тухайлбал, бүртгэл дээрх зарим аж ахуйн нэгжүүдийн хаяг нь тодорхойгүй, утасны дугаар нь өөрчлөгдсөн, зарим нь татан буугдсан,

заримынх нь үйл ажиллагааны чиглэл тодорхойгүй байсан нь судалгааны түүвэрлэлтэд уг мэдээллийг шууд авч ашиглахад боломжгүй байдлыг үүсгэж байв. Үүнээс болж судалгааны ажилд Улаанбаатар хотын бүх дүүргийн үйлдвэрүүдийг хамруулж чадаагүй бөгөөд энгийн санамсаргүй түүврээр Хан-Уул, Сүхбаатар, Баянгол дүүргүүдийн хэдхэн үйлдвэрүүдийг л судалгаанд хамруулсан юм. Эндээс судалгааны түүвэрлэлт нь Улаанбаатар хотын хэмжээнд төлөөлж чадахуйц болж чадаагүй болно. Хэдий тийм боловч үйлдвэрт ажилладаг хүүхдүүдийн хөдөлмөрийн ерөнхий нөхцөл байдлыг гаргаж чадсан гэж үзэж байна.

Түүнчлэн хүүхэд ажиллаж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжүүд ихэвчлэн нууж хааж байсан бөгөөд зарим нь хүүхдүүд ажилладгийг нуухгүй байгаа ч судалгаа авахуулахаас татгалзах зэрэг сөрөг хандлагууд тохиолдож байлаа. Тухайлбал, “UNITED APPAREL” ХХК-ны оёдлын үйлдвэр нь ажлын цагаар дотогш хэнийг ч нэвтрүүлэхгүйгээс гадна, боловсон хүчин, удирдлагын ажилтнууд нь уулзахаас татгалзаж байсан. Мөн “MM constraction”-ны боловсон хүчинтэй уулзахад цех болгонд 18 хүртэлх насын 20-30 гаруй хүүхдүүд ажилладаг нийтдээ 100-200 орчим хүүхдүүд ажилладаг, тэдгээр хүүхдүүдээс судалгаа авч болно гэсэн боловч үйлдвэрийн даргын татгалзсан хариунаас болж судлаачдыг үйлдвэрээс хөөж гаргаж байв.

Дээрх шалтгаанаар хэд хэдэн үйлдвэрүүдийн захиргаа судалгааны ажилд бэрхшээл учруулснаас гадна, үйлдвэрүүдийн ажлын цагийн хуваарь, нэг өдрийн ажлын норм зэрэг нь судалгааны ажлын нэг гол бэрхшээл болж байлаа. Үйлдвэрт ажилладаг хүүхдүүдээс өдөр цайны цагаар, орой ажлаа тараах үеэр нь л судалгаа авах боломжтой байв. Судалгааны явцад хүүхдүүд асуултад хариулахгүй удах, юу ч дуугарахгүй байх зэрэг нь мөн цаг алдалт, судалгааны ажлын сунжралтад нөлөөлж байсан юм.

Судалгааны үндсэн үр дүн

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ерөнхий шинж байдал

Монгол улсын хөдөлмөрийн хуулинд 16 нас хүрсэн хүүхдийг ажиллуулж болох, 14-15 насын хүүхдийг эрүүл мэнд, бие бялдрын хэвийн өсөлт, ёс сууртахуунд нь муугаар нөлөөлөхгүй ажилд эцэг, эх буюу тэднийг асран хамгаалагчийн зөвшөөрөлтэйгээр авч ажиллуулж болно гэсэн заалт байдаг. Гэвч манай улсад албан болон албан бус салбарт хөдөлмөрийн насандаа хүрээгүй олон тооны хүүхдүүд хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд тэдний хуулиар тогтоогдсон эрхүүд нь их, бага хэмжээгээр зөрчигдсөөр байна. Түүнчлэн хөдөлмөрийн насандаа хүрсэн буюу 16-17 насын хүүхдүүд өөрийн нас биедээ ахадсан, хүнд хэлбэрийн хөдөлмөр эрхэлж, хуулиар заагдсан эрх нь зөрчигдэх явдал цөөнгүй байгаа учраас энэхүү судалгаанд 18 хүртэлх насын оёдлын үйлдвэрт ажил эрхэлж буй хүүхдүүдийг хамруулсан.

Хүүхдийн хүн ам зүйн шинж байдал

Хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг авч үзэхдээ нас, хүйсийн бүтцийг судлах нь тухайн төрлийн хөдөлмөр эрхлэлт аль насанд давамгайлж, нөхцөл байдал нь ямар байгааг нас, хүйсийн хувьд тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Хүснэгт 3.1. Судалгаанд хамрагдсан хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн хувийн жин, насны бүлэг, хүйсээр

Насны бүлэг	Хүйс		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	
12-15	46.2	27.3	29.3
16-17	53.8	72.7	70.7
Хувь	100.0	100.0	100.0
Тоо	13	110	123
Дундаж нас	15.5	16.0	15.9

Судалгаанд оёдлын үйлдвэрт ажилладаг дунджаар 15.9 насны нийт 123 хүүхэд хамрагдсаны дийлэнх нь буюу арван хүүхэд тутмын ес нь эмэгтэй хүүхдүүд байлаа. Тэднийг насны бүлгээр авч үзвэл, хөдөлмөрийн насанд хүрээгүй буюу 12-15 насны хүүхдүүд 29,3 хувь, хөдөлмөрийн насанд хүрсэн 16-17 насны хүүхдүүд 60,7 хувийг тус тус эзэлж байв.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн харьяаллыг авч үзэхэд 74 хувь нь хотын, 26 хувь нь хөдөөнөөс ирсэн хүүхдүүд байлаа. Хөдөөнөөс ирж ажиллаж буй хүүхдүүдийн талаас илүү (59 хувь) хувь нь 8 эсвэл 10 дугаар ангия төгссөн буюу ямар нэг хэмжээгээр суурь боловсрол өзэмшсэн хүүхдүүд байв. Эндээс хөдөөний айлууд 8-р ангия төгсөөд 9-д орж чадаагүй, эсвэл 10-р ангия төгсөөд их сургуульд ороогүй хүүхдүүдээ хот руу явуулж оёдол, сүлжмэлийн сургалтанд суулган үйлдвэрүүдэд ажил хийлгэдэг дүр зураг ажиглагдаж байна.

Судалгаанд хамрагдагсдын боловсролын байдлыг сонирхож үзвэл талаас илүү хувь (52 хувь) нь боловсролгүй буюу бага боловсролтой хүүхдүүд байлаа. Хүүхдүүдийн боловсролын түвшинг хүйсээр авч үзвэл эрэгтэй хүүхдүүдийн 23.1 хувь нь огт боловсролгүй, 53.8 хувь нь бага, 7.7 хувь нь бүрэн бус дунд, 15.4 хувь нь бүрэн дунд боловсролтой, харин эмэгтэй хүүхдүүдийн 12.7 хувь нь огт боловсролгүй, 36.4 хувь нь бага, 30.0 хувь нь бүрэн бус дунд, 20.9 хувь нь бүрэн дунд боловсролтой байв.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүд бүгд сургуульд сурдаггүй, ажил эрхэлдэг хүүхдүүд байв. Гэхдээ тэдний дийлэнх (93 хувь) нь өмнө нь сургуульд суралцаж байжээ.

Сургууль завсардалт


Судалгаанд хамрагдсан оёдлын үйлдвэрт ажил эрхэлдэг нийт хүүхдүүдийн талаас илүү (61 хувь) хувь нь сургууль завсардсан байв. Сургууль завсардсан хүүхдүүдийн ихэнх нь буюу 67.2 хувь нь дунд ангиасаа (5-8-р анги), 11.4 хувь нь бага (1-4-р анги) ангиасаа, 21.4 хувь нь ахлах ангиасаа сургуулиас завсарджээ. Тэдний сургуулиас завсардсан шалтгааныг тодруулахад, өрхийн орлого нэмэгдүүлэх (30 хувь), сурх бичиг, хувцасны зардал өндөр буюу мөнгөний боломжгүй (20 хувь) гэсэн шалтгаан зонхицж байснаас харахад ядуурлын түвшин цаашилбал, нийгэм дэх ажилгүйдэл нь хүүхдүүд сургуулиас завсардах, улмаар хүүхдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх үндсэн нөхцлийг бүрдүүлж байна.

Өрхийн шинж байдал

Судалгаанд хамрагдсан хүүхдүүд дунджаар 5.3 ам бүлтэй өрхөд амьдардаг байсан бөгөөд тэдний 36.6 хувь нь өөрийн аав, ээжтэйгээ, 4.9 хувь нь зөвхөн аавтайгаа, 13.8 хувь нь зөвхөн ээжтэйгээ, 6.5 хувь нь аав, хойд ээжтэйгээ, 8.9 хувь нь ээж, хойд аавтайгаа амьдардаг, үлдсэн 29.9 хувь ээж, аавынхаа алинтай нь ч амьдардаггүй гэжээ. Өрхүүдийн 50.4 хувь нь хотын, 26 хувь нь хөдөөний, 23.6 хувь нь шилжин ирсэн өрхүүд байна.

Нийт өрхийн 10.6 хувь нь нэн ядуу, 34.1 хувь нь ядуу, 40.7 хувь нь ядуу бус доод, 14.6 хувь нь ядуу бус дунд амин зуулгатай байна⁶ (Зураг 3.1). Судалгаанд ядуу бус дээд амьжиргаатай өөрөөр хэлбэл, баян чинээлэг айлын хүүхдүүд хамрагдаагүй байна. Энэ нь амьжиргаа доогуур өрхүүдийн хүүхдүүд хөдөлмөр эрхлэх хандлагатай байгааг харуулж байна.

Зураг 3.1. Өрхүүдийн амьжиргааны түвшин, ядуурлын таван ангиллаар



⁶ НҮБХХ, ХАССТ-өөс 2004 онд хийсэн “Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн” судалгааны амьжиргааны түвшний ангиллыг ашиглав.

Судалгаанд хамрагдсан өрхүүдэд хөдөлмөр эрхэлж буй хүүхдээс нь гадна хичнээн хүн орлого олох ямар нэгэн ажил эрхэлдгийг судалж үзсэн юм. Эндээс өрхүүдийн 7.3 хувь нь зөвхөн хөдөлмөр эрхэлж буй хүүхдэд нь орлого олох ажил эрхэлдэг, 43.9 хувь нь тухайн хүүхдээс гадна 1 хүн ажил эрхэлдэг, 35.8 хувь нь 2 хүн, 11.4 хувь нь 3 хүн, дөнгөж 1.6 хувь нь 4 хүн тус тус ажил эрхэлдэг гэсэн үр дүн гарчээ.

Өрхийн амьжиргааны гол эх үүсвэрийг судалж үзэхэд, ихэнх өрхүүд буюу нийт өрхийн 84.6 хувь цалин, хөлсөөр, 8.1 хувь нь худалдаа, үйлчилгээ, наймаагаар, 6.5 хувь нь тэтгэвэр тэтгэмжээр, 0.8 хувь нь бусдын тусламж, дэмжлэгээр амьжиргаагаа залгуулж байна.

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, түүний нөхцөл байдал

Ажил эрхэлсэн анхны нас


Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ажил хийж эхэлсэн анхны нас дунджаар 15.4, харин тухайн үйлдвэртээ ажиллаж эхэлсэн нас дунджаар 15.7 байна. Ажил эрхэлсэн насыг хүйсээр авч үзвэл хөвгүүд охидыг бодвол харьцангуй эрт хөдөлмөрийн харилцаанд орж байгаа нь ажиглагдлаа. Энэхүү судалгаанд хамрагдсан хөвгүүд дунджаар 14.8 настайдаа хөдөлмөр эрхэлж эхэлсэн бол охидуудын хувьд энэ үзүүлэлт 15.4 байна.

Хүүхдүүдийн 24.4 хувь нь үйлдвэрт ажиллахаасаа өмнө нь ямар нэг ажил эрхэлж байсан байна. Оёдлын үйлдвэрт хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 4.9 хувь нь 12 настайдаа, 34.2 хувь нь 13-15 настайдаа, 61 хувь нь 16-17 настайдаа үйлдвэрт ажилд оржээ.

Ажил эрхлэлтийн шалтгаан

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгааныг тодруулахад, өрхийн орлого хүрэлцдэггүй гэсэн шалтгаанаар хүүхдүүдийн 34.1 хувь нь, өөрийнхөө хэрэгцээг хангахын тулд 34.1 хувь нь, сонирхолдоо хөтлөгдөж 21.1 хувь нь, сургууль завсардсан учраас 9.8 хувь нь, бусдын шахалт шаардлагаар 0.8 хувь нь хөдөлмөр эрхлэх болжээ (Зураг 3.2). Эндээс амьжиргааны түвшин нь хүүхдийг хөдөлмөрийн зах зээлд түлхэн оруулах нэг хүчин зүйл, шалтгаан болж байгааг харж болно.

Зураг 3.2. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувийн жин, хөдөлмөр эрхлэлтийн шалтгаанаар



Өмнө нь өөр салбарт ажил эрхэлж байсан хүүхдүүдээс ямар шалтгаанаар оёдлын үйлдвэрт ажиллах болсныг сонирхож үзэхэд, өөрийн сонирхлоороо ажлаа өөрчилсөн шалтгаан зонхицж (33.3 хувь) байв. Түүнээс гадна хүүхдүүд өмнөх ажлаа тогтвортой биш (26.7 хувь), гэрээсээ хол (13.3 хувь), бусдын дарамт, шахалт их (13.3 хувь), хэцүү (3.2 хувь) гэсэн шалтгаануудаас болж өөрчилсөн байна.

Ажил эрхлэх санаачлага


Хөдөлмөр эрхлэх санаачлагыг хүүхдүүд голдуу эхэлж өөрсдөө (35 хувь) гаргадаг нь судалгаанаас харагдаж байна. Түүнчлэн хүүхдүүдийн ар гэрийнхэн (24 хувь), найз нөхөд (17 хувь), хамаатан садан (15 хувь), танилууд (8 хувь) нь тэднийг ажил хийх санал тавьдаг ажээ. Энэ үзүүлэлтийг хүйсээр авч үзвэл, эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн хувьд ажил эрхлэхийг голлон санаачлагч нь өөрсдөө байгаа ч хөвгүүд найз нөхдийнхөө санаачлагаар ажил эрхлэх явдал охицуудаас 2 дахин өндөр хувьтай байв. Харин охицууд хөвгүүдийг бодвол гэрийнхэн, танил хүмүүсийнхээ зөвлөсний дагуу ажил хөдөлмөр эрхлэх нь илүү байдаг байна.

Судалгаанд хамрагдсан хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн хувьд, арван хүүхэд тутмын дөнгөж нэг нь гэр бүлийнхэн ажил эрхлэхэд дургүй байдаг гэжээ.

Ажлын төрөл


Судалгаанд хамрагдсан оёдлын үйлдвэрт хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн ажлын төрлийг авч үзэхэд, хүүхдүүдийн 26 хувь нь цэвэрлэгээ, 25 хувь нь индүүдлэг, 24 хувь нь оёдол, 10 хувь нь туслах, 10 хувь нь савлагч, 5 хувь нь зөөгч гэх мэт мэргэжлийн ур чадвар бага шаардсан, механик ажиллагаа илүүтэй ажлуудыг хийж байлаа.

Зураг 3.3. Хүүхдүүдийн хувийн жин, эрхэлж буй ажлын төрлөөр



Хүүхдүүдийн эрхэлж буй ажлын төрөл нас болон хүйсийн хувьд нэлээд ялгаатай байв. Оёдлын үйлдвэрт ажилладаг эрэгтэй хүүхдүүдийн талаас илүү хувь нь индүүчин болон зөөгчийн ажил хийдэг бол охидууд голдуу оёдол, индүү, цэвэрлэгээний ажил хийдэг байна.

Зураг 3.4. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувийн жин, эрхэлж буй ажлын төрөл, насны бүлгээр



Эндээс дүгнэж хэлэхэд арай бага насны хүүхдүүд цөөхөн тооны хялбархан ажлуудыг хийж, нас ахих тусам олон төрлийн ур чадвар шаардах ажлуудыг хийж байна. Харин хүйсийн хувьд, хөвгүүд охидыг бодвол нарийн нямбай ажиллагаа шаардагдахгүй ажлуудыг хийдэг гэж хэлж болно

Хүүхдүүдийн ажлын хөлс ба түүний зарцуулалт

Үйлдвэрт ажиллаж байгаа хүүхдүүд ихэвчлэн хийснээрээ цалинждаг боловч тэдний хийж буй ажлын үнэлгээ маш бага байдаг гэж ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан хүүхдүүд ярьж байлаа.

Хүүхдүүд сард дунджаар 35552 төгрөгийн цалин, хөлс авдаг бөгөөд Хүснэгт 3.2-т тэдний сарын дундаж цалин, хөлсийг хийж буй ажлын төрөл ба сонгосон үзүүлэлтүүдээр харуулав.

Хүснэгт 3.2. Оёдлын үйлдвэрт хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн сарын дундаж цалингийн дундаж хэмжээ, хүүхдүүдийн ажлын төрөл ба сонгосон үзүүлэлтүүдээр (төгрөгөөр)

Сонгосон үзүүлэлтүүд	Ажлын төрөл						Нийт
	Оёдол	Цэвэрлэгээ	Индүү	Туслах	Савлагч	Зөөгч	
Хүйс							
Эрэгтэй	0	10500	44000	27000	0	25000	31654
Эмэгтэй	56933	17355	43284	31333	21917	22500	36013
Насны бүлэг							
12-15	35000	12000	38933	25000	18600	23000	22178
16-17	57690	21676	45227	30727	24286	30000	41086
Хөдөлмөрийн гэрээтэй эсэх							
Тийм	61538	29357	48437	31000	0	0	47712
Үгүй	53441	13720	38026	30000	20727	24166	29692
Нийт (дундаж)	56933	17141	43400	30250	21917	24167	35552


Хүснэгтээс харахад цэвэрлэгээний ажил буюу бүтээгдэхүүний илүүдэл утсыг түүх ажлын үнэлгээ бусад ажлуудаас хамгийн бага байдаг нь харагдаж байна. Ийм ажлыг хийдэг хүүхдүүд бусад төрлийн ажил хийдэг хүүхдүүдтэй харьцуулахад сард дунджаар 1.3-3.3 дахин бага буюу 17141 төгрөгийн цалин хөлс авдаг ажээ. Харин хувцасны/бүтээгдэхүүний аль нэг хэсгийг⁷ оёдог хүүхдүүд бусдаасаа илүү өндөр цалинтай байна.

Хүйсийн хувьд, охидын дундаж цалин (36013 төгрөг) хөвгүүдээс (31654 төгрөг) арай өндөр байгаа нь хамгийн өндөр үнэлгээтэй байдаг оёдлын ажлыг хөвгүүд хийдэггүйтэй холбоотой болов уу. Хүүхдүүдийн нас ахих тусам өндөр үнэлгээтэй ажил хийж буй хүүхдүүдийн хувийн жин нэмэгдэж байна.

Зураг 3.5-д хүүхдүүдийн цалингийн түвшинг насны бүлгээр харуулав. Эндээс сарын дундаж цалингийн хэмжээ насны бүлгийн хувьд эрс ялгаатай байна. Судалгаанд хамрагдсан 12-15 насны хүүхдүүдийн 72 хувь нь сард дунджаар 25000-аас доош төгрөгийн цалинтай байдаг бөгөөд үлдсэн хувь нь 50000 хүртэлх төгрөгийн цалин авдаг байхад 16-17 настай хүүхдүүдийн 23 хувь нь 25000-аас доош, 44 хувь нь 25000-49999 төгрөгийн, 33 хувь нь 50000 ба түүнээс дээш төгрөгийн цалин авдаг гэсэн байна.

⁷ Бүтээгдэхүүний аль хэсгийг оёж байгаагаас хамаарч үнэлгээ нь янз бүр байдаг. Товч, шошго хадах нь хамгийн бага үнэлгээтэй бол ханцуй, зах зэрэг хэсгүүдийн нь харьцангуй өндөр үнэлгээтэй байдаг.

Зураг 3.5. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувийн жин, сарын дундаж цалин ба насын бүлгээр



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс тэдний ажил олгогчид нь тэдэнд цалингаас гадна нэмэлт урамшуулалт олгодог эсэхийг сонирхож үзэхэд 18.7 хувь нь “тийм” гэж хариулжээ. Судалгаанаас харахад хүүхдүүдийн 68.3 хувь нь цалингаас гадна хоол унааны мөнгө өгдөг гэсэн бөгөөд тэдгээр нь Диорва, Эй Ти Эм, Тэмүүжин мөнж, Айтекс, Болд трэйдинг болон Сотома зэрэг оёдлын үйлдвэрүүд ажилладаг хүүхдүүд байв. Хүүхдүүдээс цалиндаа хэр зэрэг сэтгэл хангалаун байдгийг асууж судлахад тэдний 61.8 хувь нь сэтгэл хангалаун байдаг гэжээ.

Энэ үзүүлэлт насын бүлгийн хувьд бүр ч их ялгаатай байна. Цалиндаа сэтгэл хангалаун байдаг 12-15 насын хүүхдүүдийн хувийн жин 16-17 насын хүүхдүүдтэй харьцуулахад 21 пунктээр бага байгаа юм. Энэ нь бага насын хүүхдүүд арай ахимаг насын хүүхдүүдийг бодвол харьцангуй үнэлгээ багатай хөдөлмөр эрхэлдэгтэй холбоотой байж болох юм.

Судалгаанд хамрагдсан дөрвөн хүүхэд бүрийн нэг нь цалин хөлсөө хугацаандаа тогтмол олгодоггүй гэж хариулсанаас хүүхдийн хөдөлмөрийг хэрхэн мөлжиж байгааг харуулж байна.

Хүүхдүүд ажлынхаа хөлсийг бүгдийг нь өөртөө зарцуулж чаддаггүй байна (Зураг 3.7). Тэдний талаас илүү хувь (58 хувь) нь цалингаа гэрийнхэндээ аваачиж өгдөг ажээ. Үйлдвэрт ажилладаг эрэгтэй хүүхдүүд (69 хувь) охидуудыг бодвол ажлынхаа хөлсийг гэртээ зарцуулах нь илүү (13 пунктээр өндөр) байна. Насны бүлгийн хувьд, 12-15 насын хүүхдүүдийн тал хувь нь цалингаа өөртөө зарцуулж, үлдсэн тал хувь нь гэртээ зарцуулж байхад 16-17 настай хүүхдүүдийн 69 хувь нь гэртээ, 21 хувь нь өөртөө зарцуулж байна.

Хүүхдүүдийн ажлын хөлсний зарцуулалтыг хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн нэг гол шалтгаан болох өрхийн амьжиргааны түвшнээр авч үзэхэд, нэн ядуу өрхийн хүүхдүүдийн 46.2 хувь, ядуу өрхийн хүүхдүүдийн 59.5 хувь, ядуу бус доод амьжиргаатай өрхүүдийн 64 хувь, ядуу бус дунд орлоготой өрхүүдийн 44.4 хувь нь тус бүр ажлынхаа хөлсийг гэртээ авчирч өгдөг ажээ. Гэр орныхоо хэрэгцээнд хөдөлмөрийнхөө хөлсийг зарцуулдаг хүүхдүүдийн ихэнх (72 хувь) нь өрхийнхөө амьжиргаанд боломжийн нэмэр оруулдаг бол

багагүй хувь (13 хувь) нь өрхийнхөө амьжиргааны гол эх үүсвэрийг залгуулж байна. Тэдгээр хүүхдүүдийн 15 хувь нь ажил хийснээрээ өрхийнхөө амьжиргаанд бага боловч хувь нэмрээ оруулдаг ажээ.

Гэртээ цалингаа аваачиж өгдөг 10 эрэгтэй хүүхэд бүрийн нэг нь өрхийнхөө амин зуулгыг залгуулж байгаа бол үлдсэн есөн хүүхэд нь боломжийн хувь нэмэр оруулчихдаг гэжээ. Харин охидын хувьд 12.9 хувь өрхийн амьжиргааныхаа гол эх үүсвэрийг бүрдүүлж, 69.4 хувь нь өрхийнхөө амьжиргаанд боломжийн, 17.7 хувь нь бага ч гэсэн хувь нэмэр оруулж байна.

Хүүхдүүдийнх нь цалин амьжиргааных нь гол эх үүсвэр болж байгаа өрхүүдийн хувийн жин нэн ядуу амьдралтай өрхүүдийн хувьд (33 хувь) амьжиргааны бусад түвшин дэх өрхүүдийнхээс 2.7-3.6 дахин өндөр байна.

Хүүхдийн хөдөлмөр ба хүүхдийн эрх

Хөдөлмөрийн харилцаа ба хөдөлмөрийн гэрээ

Хөдөлмөрийн хуулинд зааснаар 16 насанд хүрсэн хүн хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй. Харин 14-15 насанд хүрсэн хүнтэй эцэг, эх, асран хамгаалагч болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно гэсэн байдаг. Гэтэл судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн талаас илүү (59 хувь) нь хөдөлмөрийн гэрээ, хэлэлцээргүйгээр ажил эрхэлж байна⁸.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүд, үйлдвэрийн удирдлагатайгаа хөдөлмөрийн гэрээ байгуулсан эсэхийг хүүхдүүдийн насын бүлгээр авч үзэхэд 12-15 насын хүүхдүүд ямар ч гэрээгүй, харин 16-17 насын хүүхдүүдийн тал хүрэхгүй (46 хувь) хувь нь хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Хүйсийн хувьд энэ үзүүлэлтийг авч үзэхэд хөвгүүдийн 30.8 хувь, охидын 37.6 хувь нь л үйлдвэрийн удирдлагатайгаа гэрээ байгуулжээ.

⁸ Хөдөлмөрийн хуулийн 24-р зүйлийн 1-д “Ажил олгогч нь ажилтантай хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулж, гэрээний хувийг ажилтанд өгнө” гэснийг зөрчиж байна.

Ажлын байр, орчин нөхцөл

Хүснэгт 3.3. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувь, оёдлын үйлдвэрүүдийн ажлын байрны нөхцлийг үнэлсэн байдлаар

Ажлын орчин, нөхцөл	Хувь*
Дуу чимээ ихтэй	46.3
Гэрэл муу	7.3
Халуун	29.3
Зай багатай	12.2
Тоосжилттой	24.5
Хуурай	17.1
Агааржуулалт муу	7.3
Хувь	100.0
Тоо	41

* - давхардсан тоогоор

Монгол улсын хөдөлмөрийн хуулинд “Насанд хүрээгүй ажилтныг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажилд ажиллуулахыг хориглоно” гэж заасан байдаг ч судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн гуравны нэг нь өөрсдийн ажлын байраа ажиллахад тохиромжгүй, хувийн бус нөхцөлтэй гэж үзжээ.

Ажлын байраа ажиллахад тохиромжгүй гэж үзсэн хүүхдүүдийн хувьд шалтгааныг тодруулахад, дуу чимээ ихтэй (46 хувь), халуун (29 хувь), тоосжилттой (25 хувь), хуурай (17 хувь), зай багатай (12 хувь), гэрэл муу (7 хувь), агааржуулалт муу (7 хувь) учраас ажиллахад тохиромжгүй гэж хариулжээ.

Ажлын цагийн үргэлжлэх хугацаа ба ажлын өдөр

Хөдөлмөрийн тухай хуулинд 14-15 насны хүүхдүүд өдөрт 6 хүртэл, 16-17 насных нь 7 хүртэл цаг ажиллахаар хуульчилж өгсөн боловч оёдлын үйлдвэрт ажиллаж байгаа хүүхдүүд томчуудын нэгэн адил өглөө ажил цуглахад ирээд орой тараахад ажлаа дуусгаж байна. Хүүхдүүд хэт олон цагаар болон шөнийн цагаар ажиллаж байв.

Хүүхдүүд ажилдаа өглөө голдуу 9 цагт ирж, орой 20.30-д гэртээ харьдаг бөгөөд өдөрт дунджаар 9.5 цаг ажилладаг болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл, хүүхэд хуулинд зааснаас илүү уртасгасан цагаар ажилладаг гэсэн үг. Заримдаа ажил ихтэй үед норм гүйцээх гэж шөнийн цагаар ч ажиллах тохиолдол гардаг гэж хүүхдүүд ярьж байлаа.

Хүүхдүүдийн ажлын өдрийг авч үзэхэд, дийлэнх (90.2 хувь) нь 7 хоногийн турш, 0.8 хувь нь долоо хоногийн таван өдөр, 9.0 хувь нь зургаан өдөр ажилладаг гэжээ.

Хүүхдүүдийн долоо хоногийн ажлын цагийг насны бүлгээр авч үзвэл, 12-15 насныхан дунджаар 55.1 цаг, харин 16-17 насныхан дунджаар 66.3 цаг ажилладаг ажээ. Эндээс дүгнэж хэлэхэд оёдлын үйлдвэрт ажилладаг хүүхдүүд том хүмүүстэй харьцуулахад харьцангуй хялбар, наас, биеийнхээ онцлогт тохирсон ажил эрхэлдэг боловч хөдөлмөрийн нөхцөл, ажлын цагийн үргэлжлэх хугацаа зэрэг нь насандаа хүрсэн хүмүүстэй адил байна. Тэдний долоо хоногийн ажлын цаг нь хөдөлмөрийн хуулиар насандаа хүрсэн хүмүүсийн долоо хоногт ажиллахаар заасан (40 цаг) хугацаанаас ч урт хугацаа байгаа юм.

Хүснэгт 3.4-т хүүхдүүд илүү цагаар ажилладаг эсэхийг сонгосон үзүүлэлтүүдээр харуулав.

Оёдлын үйлдвэрүүд дэх хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор язгуур эрх ашгийг нь хөндөж буй, анхаарал татсан нэг зүйл бол хүүхдүүдийг байнга илүү цагаар буюу уртасгасан цагаар ажиллуулах явдал юм. Тэднээс илүү цагаар ажилладаг эсэхийг нь асуухад 68.3 хувь нь л ажилладаг гэжээ. Үнэн хэрэг дээрээ судалгаанд хамрагдсан хүүхдүүд бүгдээрээ байнга илүү цагаар ажилладаг боловч түүнийгээ илүү цаг гэж боддоггүй, угаасаа ажлын өдрийн үргэлжлэх хугацаа тийм байдаг мэтээр ойлгож байгаагаас харахад тэд өөрсдөө өөрсдийнхөө эрхийг хөндүүлэх, хөдөлмөрөө бусдад хямдхан ашиглуулах нөхцлийг бүрдүүлж байж болох юм. Ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан хүүхдүүдийн яриагаар захиалга ихтэй үед зарим хүүхдүүд, ихэвчлэн оёдол, индүүн дээр суудаг ахимаг насны хүүхдүүд шөнийн цагаар ажилладаг бөгөөд шөнийн цагаар ажилласныгаа илүү цаг гэж үздэг болох нь ажиглагдаж байв.

Хүүхдүүд илүү цагаар ажилладаг эсэхийг насны бүлгээр нь авч үзэхэд 12-15 насны хүүхдүүдийн тал шахам (47 хувь) хувь нь, 16-17 насны хүүхдүүдийн ихэнх (77 хувь) хувь нь илүү цагаар ажилладаг гэжээ. Харин хүйсийн хувьд энэ үзүүлэлт онцын ялгаагүй байгааг Хүснэгт 3.4-өөс харж болно.

Хүснэгт 3.4. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувийн жин, илүү цагаар ажилладаг эсэх ба сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Илүү цагаар ажилладаг эсэх		Бүгд
	Тийм	Үгүй	
Хүйс			
Эрэгтэй	69.2	30.8	100.0
Эмэгтэй	68.2	31.8	100.0
Насны бүлэг			
12-15	47.2	52.8	100.0
16-17	77.0	23.0	100.0
Хөдөлмөрийн гэрээтэй эсэх			
Тийм	92.5	7.5	100.0
Үгүй	56.6	43.4	100.0
Нийт		68.3	31.7
			100.0

Хөдөлмөрийн харилцаа үүсэхэд зайлшгүй шаардлагатай нэг чухал зүйл бол хөдөлмөрийн гэрээ гэдэгт маргах зүйлгүй. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн илүү цагаар ажилладаг эсэхийг хөдөлмөрийн гэрээ байгуулсан эсэхээр авч үзэхэд, хөдөлмөрийн гэрээтэй хүүхдүүдийн дийлэнх (92 хувь) нь, харин гэрээ байгуулаагүй хүүхдүүдийн талаас илүү (57 хувь) хувь нь илүү цагаар ажиллаж байна.

Хүснэгт 3.5. Оёдлын үйлдвэрт хөдөлмөр эрхэлж буй илүү цагаар ажилладаг хүүхдүүдийн хувийн жин, илүү цагийн мөнгө авдаг эсэх ба сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Илүү цагийн мөнгө авдаг эсэх		Бүгд
	Тийм	Үгүй	
Хүйс			
Эрэгтэй	22.2	77.8	100.0
Эмэгтэй	32.0	68.0	100.0
Насны бүлэг			
12-15	22.4	77.6	100.0
16-17	64.7	35.3	100.0
Хөдөлмөрийн гэрээтэй эсэх			
Тийм	36.2	63.8	100.0
Үгүй	24.3	75.7	100.0
Нийт		31.0	69.0
			100.0

Илүү цагаар ажилладаг гэж хариулсан хүүхдүүдээс үйлдвэрийн удирдлагын зүгээс илүү цагийн хөлс төлдөг эсэхийг нь асууж тодруулахад дөнгөж 31 хувь нь тийм гэсэн хариултыг өгчээ.

Илүү цагаар ажиллаад хөлс авдаг охидуудын өзлэх хувийн жин хөвгүүдийнхээс даруй 10 пунктээр өндөр байна. Түүнчлэн насны бүлгээр энэ үзүүлэлт нэлээд ялгаатай байна. Тухайлбал, 16-17 настай хүүхдүүдийн 64.7 хувь нь илүү цагийн хөлсөө авч чаддаг байхад 12-15 настай хүүхдүүдийн дөнгөж 22.4 хувь нь илүү цагаар ажилласныхаа хөлсийг авдаг гэжээ. Ажил олгогчтойгоо хөдөлмөрийн гэрээ байгуулсан хүүхдүүдийн хувьд энэ нь хөдөлмөрийн гэрээгүй хүүхдүүдийнхээс бараг 12 пунктээр өндөр байна.

Хүүхдүүдээс ажлынхаа дундуур амрах цаг гардаг эсэхийг нь тодруулж үзэхэд 100 хувь амардаг (өдрийн цайны цагаар) гэсэн хариулт өгснөөс харахад албан салбарт ажиллаж байгаа хүүхдүүд албан бус салбарт ажиллаж байгаа хүүхдүүдийг бодвол ажлынхаа дундуур амрах боломжтой байдгийг харж болно. Ажлын завсарлагаагаар хүүхдүүдийн тал хүрэхгүй (49 хувь) хувь нь л өдрийн хоол иддэг гэж хариулжээ. Харин бусад хүүхдүүд нь өдрийн цайны цагаар амарч (32 хувь), салхинд гардаг (19 хувь) байна. Өдрийн хоол иддэг гэж хариулсан хүүхдүүдийн хувьд байнга махтай, халуун хоол идээд байж чаддаггүй, (ундаа, печень, нарийн боов гэх мэтээр) хөнгөхөн хооплоочихдог гэж ганцаарчилсан ярилцлаганд хамрагдсан хүүхдүүд ярьж байв. Эндээс оёдлын үйлдвэрт ажиллаж буй хүүхдүүд өдөрт

хоол ундгүй шахам, зарим нь юу ч идэж уулгүй удаан хугацаагаар ажилладаг болох нь харагдаж байгаа юм.

Үйлдвэрт ажиллаж байгаа хүүхдүүдээс албан ёсны баяр, ёслолын өдрүүдэд амардаг эсэхийг асуухад бүгд амардаг гэж хариулжээ.

Эрүүл мэнд

Хүүхдийн хийж буй ажил хөдөлмөр нь хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилт, эрүүл мэндэд сөрөг нөлөө учруулахгүй байх шаардлагатай. Гэтэл хүүхдүүдийн эрхэлж буй зарим нэг хөдөлмөрийн хэлбэр нь хүүхдүүдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй амь насанд нь аюул учруулж байгаа талаар өмнөх бүлгүүдэд авч үзсэн. Түүнчлэн оёдол, сүлжмэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрийн газруудад хийсэн үзлэгээр зарим үйлдвэрүүд суурь машины газардуулга хийгдээгүй, цахилгааны газардуулга хийгдээгүйгээс хүмүүс үйлдвэрлэлийн осолд орж гэмтэж бэртэх, зарим тохиолдолд амь наасаа алдах, мөн зориулалтын бус ажлын байранд ажиллуулах болон агааржуулалтын систем хангартгүй зэрэг янз бүрийн шалтгааны улмаас ажилчдын дунд өвчлөл их байгааг тогтоосон байна (МУХЭҮК, 2003). Тиймээс оёдлын үйлдвэрт хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн эрүүл мэндийн байдал анхаарал татсан асуудлын нэг болж байгаа юм.

Оёдлын үйлдвэрт ажиллаж байгаа хүүхдүүд тэжээллэг сайн хоол унд хэрэглэхгүй, өлөн зэлмүүн байдалтайгаар бүтэн өдрийн турасгасан цагаар ажиллаж байгаагаас харахад тэд эрүүл мэндээрээ хохирч, өвчлөхгүй байна гэсэн баталгаа байхгүй л болов уу. Тиймээс судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс тэдний эрүүл мэндтэй холбоотой хэд хэдэн зүйлийг асууж тодрууллаа.

Хүүхдүүдээс ажил хийж байх үедээ үйлдвэрлэлийн осол гэмтэлд өртөж байсан эсэхийг нь сонирхоход осол гэмтэлд орж байгаагүй гэж (100 хувь) хариулцгаажээ. Харин ажил хийж байх хугацаандаа ямар нэгэн өвчинеөр өвчилсөн эсэхийг асуусан асуултад гурван хүүхэд тутмын нэг нь өвчилж байсан гэж хариулсан байна.

Ажил хийж байх хугацаандаа ямар нэг өвчин туссан охиудуудын эзлэх (34 хувь) хувийн жин хөвгүүдийнхээс 3 пунктээр өндөр байсан ба энэ үзүүлэлтийг насын булгээр авч үзэхэд, 16-17 насын хүүхдүүдийн 42.5 хувь нь өвчилсөн нь 12-15 насын хүүхдүүдтэй харьцуулахад бараг 4 дахин өндөр үзүүлэлт болж байгаа юм.

Оёдлын үйлдвэрт ажиллаж байх хугацаандаа хүүхдүүд ихэвчлэн (68 хувь) ханиад хүрч, толгой нь өвдөж (32 хувь) байсан байна. Түүнчлэн хүүхдүүдийн шүд болон шээс бэлгэсийн замын өвчинеөр (цестит) өвдөж байжээ.


Хүүхдүүдийн өвчилсөн шалтгаан нь үйлдвэрийн нөхцөлтэй холбоотой эсэхийг судалж үзэхэд, өвдөж байсан хүүхдүүдийн 41.5 хувь нь холбоотой

гэсэн хариултыг өгчээ. Хүүхдүүдийн өвчний төрлийг үйлдвэрийн нөхцөлтэй харьцуулж үзэхэд, толгой нь өвдөж байсан хүүхдүүд дуу чимээ ихтэй, агааржуулалт муу, бөгчим байдгаас болж толгой өвддөг гэж хариулсан байна. Харин ханиад хүрч байсан хүүхдүүд өвчлөлийн шалтгаанаа ажлын байр нь халуун, хүйтэн харшиж байдаг, мөн тоосжилт ихтэй, хуурай байдагтай холбон тайлбарлаж байлаа.

Хүүхдүүдэд тулгарч буй дарамт, шахалт

Ажил хийхэд хэн нэгэн дарамт, шахалт үзүүлдэг гэж хүүхдүүдийн 20.3 хувь нь хариулжээ. Ийм хариулт өгсөн эмэгтэй хүүхдийн хувь (22 хувь) эрэгтэй хүүхдүүдийнхээс 14 пунктээр, 16-17 насны хүүхдүүдийн хувь (24 хувь) 12-15 насныхнаас 13 пунктээр тус тус илүү байна (Зураг 3.6).

Зураг 3.6. Ажлын байрандаа байхдаа ямар нэг дарамт, шахалтад ортдөг хүүхдүүдийн хувийн жин, сонгосон үзүүлэлтүүдээр



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс индуу (42 хувь), оёдол (37 хувь), цэвэрлэгээний (3 хувь) ажил хийдэг хүүхдүүд бусдын зүгээс дарамт, шахалтад илүү өртдөг ажээ.


Хүүхдүүдэд голдуу цех, тасгийн эрхлэгч, дарга нар болон үйлдвэрийн удирдлагын зүгээс (72 хувь), хааяа хамт ажилладаг хүмүүс (28 хувь) нь дарамт, шахалт үзүүлдэг болох нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

Үйлдвэрт ажилладаг хүүхдүүдийн ихэнх (94 хувь) нь үйлдвэрийн захиргаанд гомдол, хүсэлт гаргах боломжтой байдаг гэсэн бол 6 хувь нь боломжгүй гэсэн хариулт өгчээ. Хүүхдүүдийн гаргасан гомдол, хүсэлтийг үйлдвэрийн захиргааны зүгээс ихэнх тохиолдолд (97 хувь) шийдвэрлэж өгдөг байна.

Хүүхдүүдийн ажил, хөдөлмөр эрхлэх болон суралцах ирээдүйн хүсэл эрмэлзлэл

Нийт хүүхдүүдийн 17.1 хувь (эрэгтэй хүүхдүүдийн 15.4 хувь, охидын 17.3 хувь) нь цаашид одоогийн хийж буй ажлаа үргэлжүүлэн хийнэ гэжээ. Энэ үзүүлэлтийг насны бүлгийн хувьд авч үзвэл, 16-17 насны цаашид ажлаа үргэлжүүлнэ хийх хүсэлтэй хүүхдүүдийн хувийн жин (19 хувь), 12-15 настай хүүхдүүдийнхээс 8 пунктээр өндөр байна (Зураг 3.7).

Зураг 3.7. Одоогийн ажлаа үргэлжлүүлэн хийнэ гэж бодож байгаа хүүхдүүдийн хувь, сонгосон үзүүлэлтүүдээр




Нэн ядуу өрхүүдийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 23 хувь нь одоогийн эрхэлж буй ажлаа үргэлжлүүлж хийх сонирхолтой байгаа бөгөөд энэ үзүүлэлт нь ядуу өрхүүдийн хувьд 10 хувь, ядуу бус доод амьжиргааны түвшинтэй өрхүүдийн хувьд 20 хувь, ядуу бус дунд өрхүүдийн хувьд 22 хувьтай байна.

Хүүхдүүдийн одоогийн ажлаа үргэлжүүлэх сонирхолтой байгаа шалтгаан нь нэгдүгээрт: ар гэрийн амьдрал тааруухан учир мөнгө олох шаардлагатай (38.1 хувь), хоёрдугаарт: өөр ажил олдохгүй/мэргэжилгүй (38 хувь), гуравдугаарт: энэ ажилдаа дассан/дур сонирхолтой (19.1 хувь), дөрөвдүгээрт: үйлдвэрийн ажилчдын дотуур байранд амьдардаг (4.8 хувь) гэсэн шалтгаанууд болж байв.

Ерөнхий боловсролын сургуульд суралцах, мэргэжлийн сургуульд суралцах, ажиллах эсвэл ажлынхаа хажуугаар суралцах боломжууд олдвол та алийг нь сонгох вэ гэсэн асуултыг судалгаанд хамрагдсан хүүхдүүдэд тавьсан юм. Тэгэхэд хүүхдүүдийн 8.1 хувь нь ЕБС-д суралцах, 39.8 хувь нь мэргэжлийн сургуульд суралцах, 21.1 хувь нь ажиллах, 30.9 хувь нь ажлынхаа хажуугаар суралцах сонирхолтой байв (Зураг 3.8).

Зураг 3.8. Хүүхдүүдийн эзлэх хувийн жин, суралцах болон ажиллах ирээдүйн хүсэл эрмэлзэлээр



Бага насыханд суралцах сонирхол өндөр байхад 16-17 насыханд ажиллахын хажуугаар суралцах, эсвэл ажиллах боломжуудыг сонгосон байна. Хүйсийн хувьд, охид мэргэжлийн сургуульд суралцах (38 хувь), ажиллах (22 хувь), ажлын хажуугаар суралцах (32 хувь) боломжуудыг илүү сонгосон байхад эрэгтэй хүүхдүүд мэргэжлийн сургуульд суралцах (54 хувь), ажиллахын хажуугаар суралцах боломжийг арай илүү сонгосон байлаа.

Ар гэрийнхэн нь тухайн хүүхдийг сургууль, курст суралцуулахад зохих дэмжлэг үзүүлэх талаар оролцогч хүүхдүүдээс өөрсдөөс нь асуухад бүгд дэмжлэг үзүүлнэ гэжээ.

Өрх гэртээ орлого оруулахад нэмэр болж буй энэ ажлаа орхиод суралц гэвэл танай гэр бүлийнхэнд хүнд байх уу гэсэн асуултанд 49.7 хувь нь тийм гэжээ. Насны бүлэг нэмэгдэх тусам гэрийнхэн маань хэцүүднэ гэж үзэж байгаа хүүхдийн хувийн жин эрс нэмэгдэж байна. Мөн ийм хариулт өгсөн эрэгтэй хүүхдийн хувийн жин охидоос илүү байна.

Хүүхдүүд ирээдүйд ямар боловсрол, мэргэжилтэй болохыг хүсч байгааг тодорхойлж үзэхэд 31.2 хувь нь багш, 21.3 хувь нь эмч, 17.5 хувь нь эдийн засагч, 7.0 хувь нь оёдолчин, үлдсэн хувь нь бусад мэргэжилтэй болохыг хүсч байна гэжээ.

Дүгнэлт

Судалгааны ажлын хүрээнд Улаанбаатар хотын оёдлын үйлдвэрүүдэд хөдөлмөр эрхэлж байгаа 18 хүртэлх насын хүүхдүүдийн хөдөлмөрийн шалтгаан, нөхцөл байдал, хүүхдүүдийн ажлын төрөл, хэлбэр болон хүүхдийн эрх хөндөгдөж байгаа эсэхийг судалж үзлээ.

Судалгаанаас дараахь гол үр дүнгүүдийг гарган авлаа. Үүнд:

- ◆ Судалгаанд оёдлын үйлдвэрт ажилладаг дунджаар 15.9 насны нийт 123 хүүхэд хамрагдсаны дийлэнх нь буюу арван хүүхэд тутмын ес нь эмэгтэй хүүхдүүд байлаа.
- ◆ Судалгаанд хамрагдсан оёдлын үйлдвэрт ажил эрхэлдэг нийт хүүхдүүдийн гуравны нэг нь сургууль завсардсан байв.
- ◆ Харьцангуй доогуур амьжиргаатай өрхүүдийн хүүхдүүд хөдөлмөр эрхлэх хандлагатай байна.
- ◆ Өрхийн орлого хүрэлцдэггүй, эсвэл өөрийнхөө хэрэгцээг хангах явдал хөдөлмөр эрхлэх гол шалтгаан болж байв.
- ◆ Оёдлын үйлдвэрт ажилладаг хүүхдүүд голдуу цэвэрлэгээ, индүү, оёдол, туслах, савлагч, зөөгчийн ажлуудыг хийж байна. Хүүхдүүдийн ажлын төрлийг хүйсээр авч үзэхэд эрэгтэй хүүхдүүдийн талаас илүү хувь нь индүүчин болон зөөгчийн ажил хийдэг бол охидууд голдуу оёдол, индүү, цэвэрлэгээний ажил хийдэг байна. Харин насны бүлгийн хувь хүүхдүүдийн нас ахих тусам цэвэрлэгээний болон зөөгчийн ажил хийдэг хүүхдүүдийн хувийн жин буурч, харьцангуй хүндэвтэр, ур чадвар шаардсан (оёдол, индүү гэх мэт) ажлуудыг хийдэг хүүхдүүдийн хувийн жин нэмэгдэж байлаа.
- ◆ Хүүхдүүд сард дунджаар 35552 төгрөгийн цалин, хөлс авдаг бөгөөд ажлын төрлөөс хамаараад авч буй цалингийн хэмжээ, түүнээс авч буй сэтгэл ханамж нь ч харилцан адилгүй байна. Нийт хүүхдүүдийн гуравны нэг нь цалиндаа сэтгэл хангалаан байна.
- ◆ Хүүхдүүдийн талаас илүү хувь (58 хувь) нь цалингаа гэрийнхэндээ аваачиж өгдөг ажээ. Хүүхдүүдийнх нь цалин амьжиргааных нь гол эх үүсвэр болж байгаа өрхүүдийн хувийн жин нэн ядуу амьдралтай өрхүүдийн хувьд амьжиргааны бусад түвшин дэх өрхүүдийнхээс 2.7-3.6 дахин өндөр байна. Энэ нь ядуурал хүүхдийн хөдөлмөрийн нэг гол шалтгаан болж байгаагийн илрэл юм.
- ◆ Хөдөлмөрийн харилцаа үүсэхэд зайлшгүй шаардлагатай нэг чухал зүйл бол хөдөлмөрийн гэрээ гэдэгт маргах зүйлгүй. Гэтэл судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн талаас илүү нь хөдөлмөрийн гэрээ, хэлэлцээргүйгээр ажил эрхэлж байна.
- ◆ МУ-ын Хөдөлмөрийн хуулинд “Насанд хүрээгүй ажилтныг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажилд ажиллуулахыг хориглоно” гэж заасан байдаг ч судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн гуравны нэг нь өөрсдийн ажлын байраа ажиллахад тохиромжгүй, хэвийн бус нөхцөлтэй гэж үзжээ.
- ◆ Оёдлын үйлдвэрт ажиллаж буй хүүхдүүдийн эрх ашиг хөндөгдэж байгаа эсэх талаар судалж үзэхэд нэлээд анхаарал татахуйц дүр зураг ажиглагдлаа. Тухайлбал, хүүхдүүдийн ихэнх нь долоо хоногийн турш тасралтгүй ажилладаг бөгөөд заримдаа илүү цагаар, оройн цагаар ажиллах явдал цөөнгүй тохиолддог. Түүнчлэн илүү цагийн ажлын хөлсөө ихэнх тохиолдолд авч чаддаггүй зэргээс хараад хүүхдүүдийг амрах, суралцах, өөрийгөө хөгжүүлэх боломжийг хөсөрдүүлж нь хямдхан хөлсөөр хөдөлмөрийг нь мөлжиж байгаа байдал ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл хуулиар тогтоосон эрхийг нь хөсөрдүүлж⁹ байгаа юм.

⁹ Оёдлын үйлдвэрт ажиллаж буй хүүхдүүдийн хувьд хөдөлмөрийн хуулийн 53.1, 71.1, 83.1, 109.1, 109.2, 110.2, 110.3-р зүйлээр заагдсан эрх, ашиг нь зөрчигдэж байна.

- ◆ Хэдийгээр оёдлын үйлдвэрүүдэд ажиллаж буй хүүхдүүдийн эрх байнга зөрчигдэж байдаг ч гэсэн нийт хүүхдүүдийн тавны хоёр орчим хувь нь цаашид одоогийн хийж буй ажлаа үргэлжүүлэн хийнэ гэсэн бодолтой байна. Тэдний одоогийн ажлаа үргэлжүүлэх сонирхолтой байгаа шалтгаан нь *нэгдүгээрт*: ар гэрийн амьдрал тааруухан учир мөнгө олох шаардлагатай, *хоёрдугаарт*: өөр ажил олдохгүй/мэргэжилгүй, *гураевдугаарт*: энэ ажилдаа дассан/дур сонирхолтой, *дөрөвдүгээрт*: үйлдвэрийн ажилчдын дотуур байранд амьдардаг гэсэн шалтгаанууд болж байв.
- ◆ Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 8.1 хувь нь боломж олдвол ЕБС-д сурх, 39.8 хувь нь мэргэжлийн сургуульд суралцах, 21.1 хувь нь ажиллах, 30.9 хувь нь ажлынхаа хажуугаар суралцах сонирхолтой байв.

Зөвлөмж

Сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдсээр байгаа хүүхдийн хөдөлмөр эрхлэлт нь шилжилтийн үеийн нөлөөгөөр бий болсон ядуурал, ажилгүйдлийн түвшин болон сургууль завсардалтаас үүдэлтэй. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг шууд хориглох, хүүхдийг хөдөлмөрөөс албан хүчээр хөндийрүүлэх нь тийм ч үр дүнтэй алхам биш учраас энэхүү судалгааны ажлын үр дүн дээр үндэслэн хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар цаашид авч хэрэгжүүлэх талаарх дараах зөвлөмжийг судлаачийн зүгээс санал болгож байна. Үүнд:

- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн томоохон шалтгаан болох өрхийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, үүнтэй уялдан өрхөд ажилгүй байгаа насанд хүрэгсдийн ажил эрхлэх боломж, нөхцлийг дээшлүүлэх;
- Албан бус салбарт ихэвчлэн хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхдүүд ажиллаж байгаатай холбоотойгоор тэдгээр хүүхдүүдийн ажлын нөхцлийг хөнгөрүүлэх, хуулиар заагдсан эрхийн хэрэгжилтэд нь хяналт тавих. Өөрөөр хэлбэл, хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хуулийн хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулах;

Номзүй

1. Featured in UNISEF's Situation Analysis Report-2000: Children and Women in Mongolia
2. Монгол улсын хүний эрхийн үндэсний комисс, “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл”, УБ 2003. /9-13, 36-39 дүгээр тал/
3. Монголын хүүхдийн эрхийн төв, Норвегийн хүүхдийг ивээх сан, Г. Батчимэг, “Зах зээлийн үеийн хүүхдийн хөдлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал”, УБ 2000.
4. МУ-ын Үндэсний статистикийн газар, 2000 оны Хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн, 2001
5. МУ-ын Үндэсний статистикийн газар, Хүүхэд, хөгжил-2000 судалгаа, Монгол улс, Үндэсний тайлан. /21-26 дугаар тал/
6. Н. Содномдорж, Монгол улсын хүүхдийн хөдөлмөр, “Хүүхдийн хөдөлмөр” сургалт-семинар дээр тавьсан илтгэл, УБ 1998.10.28.
7. НҮБ-ын Хүүхдийн сан, “Дэлхийн хүүхдийн байдал, 2000 онд” илтгэл, Хүүхдийн сайн сайхны төлөө манлайлах нь, УБ 2001.
8. “НЭГ ЕРТӨНЦ” НҮБ-ын цуврал бага хурал, “Хүүхэд”, “Хүний эрх”, “Хүн ам ба хөгжил” бага хурлын тайлан, 21-р зууныг зорин буй залуу үе, Монгол улс, 1998.11.20-23. /17, 21 дүгээр тал/
9. ОУХБ, Олон улсын парламентийн холбоо, “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах нь”, Парламентийн гишүүдэд зориулсан гарын авлага, №3, УБ 2002.
10. ОУХБ, МУИС-ын ХАССТ, “Алт олборлогч хүүхдийн ажлын нөхцөл байдал” судалгааны тайлан, УБ 2002.
11. ОУХБ, МУИС-ын ХАССТ, “Улаанбаатар хотын захууд дээр хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн нөхцөл байдал” судалгааны тайлан, УБ 2002.
12. ОУХБ, НХХЯ, “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй тэмцэх шинэ арга хэрэгсэл”, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар Конвенц.
13. ОУХБ, ҮСГ, “Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа, 2002-2003”, УБ 2004.
14. Р.Жадамбаа, “Монгол орон дахь хүүхдийн хөдөлмөрийн өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт, хяналт”, Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх үндэсний зөвлөлдөх уулзалтад тавьсан илтгэл, УБ 2002.
15. Т. Амгалан, Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт ба жендерийн асуудал, “Хүүхдийн хөдөлмөр” сэдэвт сургалт-семинарт уншсан лекцээс, УБ 2003.
16. Хүүхдийн төлөө үндэсний хороо, НҮБ-ын хүүхдийн сан, Английн хүүхдийг ивээх сан, “Нийслэлийн захын хороололд болон бусад хотуудад амьдарч буй хүүхдийн амьдралын байдал” судалгааны тайлан, УБ 2002.
17. Ш.Оюунбилэг, Р.Ганпүрэв, “Насанд хүрээгүй хүүхдүүд хууль бусаар ажиллаж байна уу?” баримтат нийтлэл, Өдрийн сонин, 2000 оны 12 сарын 9, №290 (543).